

БНЧУ-ын нутаг дэвсгэр дээр байнга оршин суух зөвшөөрөл хүсэх өргөдөлд бүрдүүлбэл зохих баримт материалууд

Хуулийн эмхтгэлийн 1999 оны 326-р хуулийн 68-р зүйлийн 1-р заалтын дагуу БНЧУ-ын нутаг дэвсгэр дээр байнга оршин суух зөвшөөрөл хүсэх өргөдөлд бүрдүүлбэл зохих баримт материалууд

Гадаад хүн нь хуулийн эмхтгэлийн 1999 оны 326-р хуулийн 68-р зүйлийн дагуу байнга оршин суух зөвшөөрөл хүссэн өргөдөлд (хуулийн эмхтгэлийн 1999 оны 326-р хуулийн 70-р зүйлийн 2-р заалтын дагуу – 2009. 1. 1-ээс хүчинтэй) доорх бичиг баримтыг бүрдүүлнэ:

- 1) цээж зураг (2 ширхэг) (70-р зүйлийн 2а заалт)
- 2) гадаад паспорт (70-р зүйлийн 2б заалт)
- 3) нутаг дэвсгэр дээр байнга оршин суухад шаардагдах мөнгөний баталгаа (70-р зүйлийн 2д заалт)

Тогтоомжийн эмхтгэлийн 1999 оны 326-р хуулийн 71-р зүйлийн 1-р заалтын дагуу БНЧУ-ын нутаг дэвсгэр дээр байнга оршин суухад шаардлагатай мөнгөний баталгаа гэдэг нь гадаад хүн болон түүнтэй хамт тооцогдох хүмүүсийн [42ц зүйлийн 3 ц анги] сарын орлогын нийт дүн нь гадаад хүн болон түүнтэй хамт тооцогдох хүмүүсийн амьжиргааны доод хэмжээний нийт дүнгээс доогуур биш (амьдралын болон амьжиргааны доод хэмжээний тухай эмхтгэлийн 2006 оны 110-р хуулийн 2 ба 3-р зүйлийг үз) гэдгийг нотолсон баримт, орон сууцны тэтгэлэг олгох тусгай хуулийн заалтаар тогтоосон орон сууцны зардлын хамгийн дээд хэмжээ (улсын нийгмийн тэтгэмжийн тухай эмхтгэлийн 1995 оны 117-р хуулийн 26-р зүйлийн 1-р заалтыг үз) эсвэл гадаад хүн өөрийн болоод хамт тооцогдох хүмүүсийн оршин суухад гарсан бодит зардлыг нотолсон баримт зэрэг болно. Хамт тооцогдох хүмүүс гэдэг нь эмхтгэлийн 1999 оны 326-р хуулийн зорилгоор 42ц зүйлийн 3ц заалтын дагуу амьдралын болон амьжиргааны доод хэмжээний тухай хуулийн 4-р зүйлийн 2, 3-р ангид заасан нөхцлийг хангавал амьдралын болон амьжиргааны доод хэмжээний тухай хуулийн 4-р зүйлийн 1а-ц-д заасан иргэдийг хэлнэ.

- 4) Гадаад хүн тухайн харьяат эсвэл байнга оршин суудаг эсвэл гадаад хүн сүүлийн 3 жилд 6 сараас дээш хугацаагаар тасралтгүй амьдарсан улсаас олгосон Гэмт хэрэг, зөрчилд холбогдож байгаагүй тодорхойлолт (70-р зүйлийн 2э заалт болон 174-р зүйл). Тухайн улс ийм тодорхойлолт гаргадаггүй тохиолдолд шударга мэдэгдэл бичих. Энэхүү үүрэг 15-аас доош насны гадаад иргэд, нутаг дэвсгэр дээр хүлээх зорилгоор 90-ээс дээш хоногийн виз эсвэл хуулийн тусгай зааврын дагуу нэмэлт хамгаалалт олгогдон, нутаг дэвсгэр дээр хүлээх зорилгоор удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл авсан 15-аас дээш насны гадаадын иргэдэд хамаарахгүй. 68-р зүйлийн 1-р ангийн дагуу байнга оршин суух зөвшөөрөл хүсч буй гадаад иргэн гэмт хэрэг, зөрчилд холбогдож байгаагүй тодорхойлолтыг шаардсан тохиолдолд авчрах үүрэгтэй. (БНЧУ-ын Дотоод яам эмхтгэлийн 1999 оны 326-р хуулийн 68-р зүйлийн 1-р ангийн дагуу байнга оршин суух зөвшөөрөл хүссэн тохиолдолд энэхүү тодорхойлолтыг заавал шаардана.)
- 5) нутаг дэвсгэр дээр амьдрах байрны тухай тодорхойлолт (70-р зүйлийн 2ф заалт) 1999 оны 326-р хуулийн 71-р зүйлийн 2-р тогтоомжийн дагуу байрны тухай тодорхойлолт гэдэг нь 70-р зүйлийн 2ф заалтын дагуу байр болон байшингийн өмчлөгч, байр ашиглах эрхийн тухай эсвэл зохих эрх бүхий хүний гадаад хүн байрлуулахтай зөвшөөрсөн тодорхойлолт дээр албан ёсоор баталгаажуулсан гарын үсэгтэй баримтыг хэлнэ. Тусгай хуулийн заалтын дагуу байр нь дүүрэг

болон бүртгэлийн эсвэл гудамжны дугаараар дугаарлагдсан байх ёстой ба барилгын хуулийн дагуу оршин суух эсвэл хувийн амралтанд зориулагдсан байх ёстой. Хэрэв эрх бүхий хүн зөвшөөрч цагдаагийн байгууллага эсвэл яамны томилогдсон ажилтны өмнө гарын үсэг зурвал албан ёсны баталгаа шаардагдахгүй.

6) эцэг эх, эсвэл өөр хууль ёсны төлөөлөгч, асран халамжлагчтай хамт амьдрахгүй тохиолдолд хүүхэд нутаг дэвсгэр дээр байнга оршин суухтай эцэг эх, хууль ёсны төлөөлөгч, асран халамжлагч нарын зөвшөөрөл. Хэрэв гадаад хүн энэхүү баримтыг түүнээс хамаарагдахгүй шалтгаанаас бүрдүүлэх боломжгүй тохиолдолд хамаарахгүй (70-р зүйлийн 2г заалт).

7) Хэрэв өөрөөр заагаагүй бол (70-р зүйлийн 2-р ангийн х заалт) Боловсрол, залуучууд ба биеийн тамирын яамнаас (182-р зүйлийн 2-р анги) тогтоосон журмаар чех хэлний мэдлэгийг шалгах эрх бүхий сургуулиудын жагсаалтанд орсон сургуулиас олгосон чех хэлний шаардлагатай мэдлэгийг тодорхойлсон баримт

Тогтоомжийн эмхтгэлийн 1999 оны 326-р хуулийн 70-р зүйлийн 5-р заалтын дагуу энэхүү баримтыг доорх гадаад иргэдээс шаардахгүй. Үүнд:

- 15 нас хүрээгүй (а заалт),
- байнга оршин суух зөвшөөрөл хүсэх өргөдөл өгөхөөс өмнөх 20 жилийн хугацаанд чех хэлээр сургалт явуулдаг бага эсвэл дунд сургуульд хамгийн багаар 1 хичээлийн жил тасралтгүй сурсан (б заалт) бол,
- 66 ба 67 эсвэл 87-р зүйлийн 7-р ангийн а заалтын 4 (ц)-ийн дагуу байнга оршин суух зөвшөөрөл хүчингүй болсон хойно байнга оршин суух зөвшөөрөл хүсэгч,
- түүний харилцах чадварт нөлөө үзүүлэхүйц биеийн болон сэтгэцийн эмгэгтэйг нотолбол (д заалт),
- 60 нас хүрсэн бол (э заалт).